

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан  
огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Нийслэлийн мал эмнэлгийн газар

Нийслэлийн мал эмнэлгийн газар

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Нийслэлийн мал эмнэлгийн газрын  
дарга

Эрхэлсэн түшмэл, ТЗ-11

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг

БГД, 2-р хороо, Чингүнжавын гудамж,  
Нийслэлийн Мал эмнэлгийн газрын  
байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд салбарын бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, мал эмнэлгийн ажил, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангуулах, мал, амьтны өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийтийн эрүүл мэндийг хамгаалах чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг агентлагийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Мал эмнэлгийн салбарын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих.

2. Байгууллагын санхүүгийн болон хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх.

3. Харьяалах нутаг дэвсгэртээ мал эмнэлгийн үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлэх ажилд мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих.

4. Газрын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавих.

| Зорилт                    | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг  | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт                                    | Хариуцлага, оролцооны хэлбэр<br>Туслах -Т,<br>Гүйцэтгэх -Г,<br>Хянах -Х,<br>Шийдвэрлэх -Ш |
|---------------------------|---|--|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1. Мал эмнэлгийн салбарын талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын мөрийн хөтөлбөр үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;  | Хуулийн дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.                | Г, Х, Ш   |
|                           | 2. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, хэрэгжүүлэх;   |  | Г, Х  |
|                           | 3. Мал, амьтны өвчинтэй тэмцэх арга хэмжээг хуулийн дагуу хэрэгжүүлэх, зохион байгуулах;  |  | Г   |
|                           | 4. Нийтийн эрүүл мэндийг хамгаалах чиг үүргийн хүрээнд мал амьтнаас хүнд халдварладаг өвчинтэй тэмцэх, хяналтанд авах арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах;                                       |  | Г   |
|                           | 5. Салбарын хууль болон тэдгээрт нийцүүлэн гарах захиргааны хэм хэмжээний акт, бусад баримт бичгийг боловсруулахад санал өгөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;                                      |  | Г, Х, Ш   |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1. Байгууллагын төсвийн төсөөллийг дээд байгууллагад хүргүүлэх, батлагдсан төсвийг тогтоосон журмын дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлд хяналт тавих, санхүүгийн дүрэм журам стандартыг мөрдөн ажиллах; | Төсвийн сахилга бат сайжирч, боловсон хүчний нөөц бүрдсэн байна. | Г   |



|                           |  |   |         |
|---------------------------|--|---|---------|
|                           | 2.Байгууллагын хүний нөөцийн эрэлт хэрэгцээг тодорхойлон, боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг дээшлүүлэх чиглэлээр сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх;  |   | Г, Х    |
|                           | 3.Байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах;  |   | Г       |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1.Хариуцсан нутаг дэвсгэрт мал эмнэлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, иргэнийг мэргэжил арга зүйн зөвлөгөө мэдээллээр хангаж, хяналт тавьж ажиллах, холбогдох байгууллагатай хамтарсан хяналт шалгалт явуулах;                    | Хууль тогтоомжид заасан үндэслэл журмын дагуу зөрчлийн шалган шийдвэрлэсэн байна. | Г       |
|                           | 2.Мал эмнэлгийн улсын байцаагч нар зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулж байгаа эсэхэд хяналт тавьж, хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллах;  |   | Г       |
|                           | 3.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн баримт бичгүүдийг холбогдох журмын дагуу хууль зүйн үндэслэлтэй бүрдүүлж, оролцогчийн эрх үүргийг хангаж ажиллах;   |   | Г       |
|                           | 4.Эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг эс зөвшөөрч холбогдогчийн гаргасан гомдол, эсхүл хүчингүй болгох, өөрчлүүлэхээр прокурорын гаргасан дүгнэлтийн дагуу шүүхээс хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, тайлбар хүргүүлэх, нотлох; |   | Г       |
|                           | 1.Байгууллагын стратеги зорилтын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчтай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулан биелэлтийг хангаж, үр дүнг хариуцах;   | Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна.  | Г, Х, Ш |
|                           | 2.Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайлалыг   | Төлөвлөлт нь төрийн   | Г, Х, Ш |



|                           |   |  |   |
|---------------------------|---|--|---|
| 4 дугаар зорилтын хүрээнд | хэрэгжүүлж, албан хаагчдыг аливаа сахилга, хариуцлага, ашиг сонирхлын зөрчил гарахаас сэргийлэх, зөвлөгөө өгөх, хяналт тавих;               | бодлого, хөтөлбөртэй уялдсан байна.                              |   |
|                           | 3.Эрхэлсэн ажлын чиглэлээр нутгийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтанг мэдээллээр хангаж, хамтран ажиллах;                   | Үнэн зөв, бодит мэдээ, мэдээллээр хангагдсан байна.              | Г |
|                           | 4.Байгууллагын дотоод дүрэм, журам, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдлөг болгон ажиллах, төрийн захиргааны манлайллыг хэрэгжүүлэх; | Дүрэм, журам ёс зүйн хэмжээнд заасан манлайлал бий болсон байна. | Г |

### III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

|           |   |   |
|-----------|---|---|
| Боловсрол | Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй;   |   |
| Мэргэжил  | Малын их эмч, Мал эмнэл зүй   |   |
| Мэргэшил  | Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтанд хамрагдаж төгссөн байх                                   |   |
| Туршлага  | Төрийн албанд 12-оос доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх |   |
| Ур чадвар | Удирдан зохион байгуулах  | <ul style="list-style-type: none"> <li>-нэгжийн үйл ажиллагааг агентлагийн үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах;</li> <li>-албан хаагчийн санал, бодлыг сонсох, эргэх холбоотой байх;</li> <li>-үл ойлголцол, саналын зөрүүг эв зүйгээр зохицуулах;</li> <li>-албан хаагчийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, зөрүүг арилгахад туслах, зөвлөх, чиглүүлэх, шаардлага тавих;</li> <li>-байгууллагын албан хаагчдад ажил үүргийг тэнцвэртэй хуваарилах;</li> <li>-нэгжийн албан хаагчийн мэдлэг, ур чадварыг бүрэн дайчлах;</li> <li>-нэгжийн үйл ажиллагаан дахь эрсдэлийг илрүүлэх, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулах, танилцуулах;</li> <li>-бусад;</li> </ul> |
|           | Дүн шинжилгээ хийх  | <ul style="list-style-type: none"> <li>-мэдээлэлд тулгуурлан чиг үүргийн болон хяналт шинжилгээ үнэлгээ хийж санал, зөвлөмж, боловсруулах;</li> <li>-судалгааны үр дүн, шийдлийн хувилбаруудын шууд ба шууд бус үр дагаврыг харьцуулан үнэлж, санал зөвлөмжийн төсөл боловсруулах, танилцуулах;</li> </ul>  |



|  |                    |  |
|--|--------------------|--|
|  |                    | -бусад;  |
|  | Асуудал шийдвэрлэх | -хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах;<br>-аливаа харилцааг зохицуулах арга замыг хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн төсөлд тусгуулах санал боловсруулах;<br>-аливаа асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх;<br>-гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах;<br>-тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах;<br>-бусад;  |
|  | Манлайлах          | -ёс зүйн хэм хэмжээг сахиж зарчимч, тууштай, ажил хэрэгч чанар, бусдыг дэмжих, чиглүүлэх зэргээр үлгэрлэх;<br>-нэгжийн үйл ажиллагаанд шинэлэг санаа, үйлчилгээг нэвтрүүлэх, албан хаагчдын шинэ санаачилга, бүтээлч үйл хандлагыг дэмжих;<br>-хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд нэгжийн хамт олныг манлайлах;<br>-байгууллагын болон нэгжийн үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олонд тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх;<br>-нэгжийн стратеги зорилтыг тодорхойлохдоо хамт олны саналыг сонсох, тусгах, өөрчлөлтийг хийхдээ урьдчилан тооцоолж, манлайлан удирдах;<br>-бусад; |
|  | Бусад              | -англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах;<br>-багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дэмжих, бусдад таниулах;<br>-харилцааны орчин үеийн арга хэлбэрийг ашиглах, мэдээллийг хүргэх;<br>-албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах;<br>-компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах;  |

#### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

- Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга



|  |   |
|--|---|
| <p><u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хэлтэсийн дарга, байцаагч, мэргэжилтнүүд</li> <li>- Лабораторын эмч, ажилтнууд</li> <li>- Хяналтын цэгийн байцаагч</li> <li>- Үйлчилгээний ажилтнууд</li> </ul> <p>Нийт:</p> | <p><u>Бусад харилцах субъект:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Яам, агентлагын дарга, мэргэжилтнүүд</li> <li>- Орон нутгийн удирдлагууд болон төрийн байгууллагын холбогдох албан тушаалтан</li> <li>- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага</li> <li>- Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага</li> </ul> |
|--|---|

**V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ**

|  |   |
|--|---|
| <p><u>Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:</u></p> | <p><u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u></p> |
|--|---|

|  |   |
|--|---|
| <p><u>Албан тушаал:</u><br/> МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АХТАХ МЭРГЭЖИЛТЭН<br/> ..... З.БАТСҮЛД<br/> (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br/> 2019 оны 09 дугаар сарын 10 -ны өдөр</p> | <p><u>Байгууллагын нэр:</u><br/> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ<br/> <u>Шийдвэрийн огноо:</u> 19 10 02<br/> <u>Дугаар:</u> 87</p> |
|--|---|

**VI. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:**

|   |  |
|---|--|
| <p><u>Байгууллагын нэр:</u><br/> МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР<br/> <u>Шийдвэрийн огноо:</u> .....<br/> <u>Дугаар:</u> .....<br/> (тамга/тэмдэг)<br/> ДАРГА..... Д. ТҮМЭНДЭМБЭРЭЛ<br/> (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br/> 20... оны ... дугаар сарын ... -ны өдөр</p> |  |
|---|--|